



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Хийн дасгал болон аэробикийн сургагч багш бэлтгэх сургалт семинар зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг зорилгоор ТУШААХ нь:


1. Хийн дасгал болон аэробикийн сургагч багш бэлтгэх сургалт семинарыг 2017 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 08-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт семинарт шаардагдах 1.500.000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.


4. Сургалт семинарын урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны сентябрь сарын 29-ны өдрийн
А/44 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Хийн дасгал болон аэробийкийн сургагч
багш бэлтгэх сургалт семинар зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын зардал: 10 хоног х 40цаг х 20төг	800.000
2.	Заал талбайн зардал:	600.000
3.	Сертификат хэвлүүлэх	100.000
ДҮН:		1.500.000


Боловсруулсан

А.Болдмаа

Хянасан

О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны *есдүмр* сарын *29*-ны өдрийн
A/47 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Хийн дасгал болон аэробийн сургагч багш бэлтгэх
сургалт семинарын хичээл заах
багш нарын бүрэлдэхүүн

1. Ц.Март Монголын гимнастикийн холбооны зөвлөх багш
2. Х.Оюунчимэг Монголын бие тэтгэх хийн дасгалын холбооны тэргүүн
3. А.Болорцэцэг Монголын гимнастикийн холбооны зөвлөх багш
4. А.Болдмаа ННБТСХ-ны НБТХөгжлийн хэлтсийн дарга
5. Ж.Тунгалаг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны мэргэжилтэн